

## “ШУУДАНГИЙН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТ-2022”

### ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

“Шуудангийн салбарын зохицуулалт-2022” зөвлөгөөнд оролцогчид Монгол Улсын шуудангийн үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулан, ДШХ-ноос тодорхойлж байгаа шуудангийн хөгжлийн дөрвөн тулгуур зорилт болох найдвартай, далайцтай, уялдаа холбоотой, уян хатан хөгжлийг чиг баримжаа болгон төрийн захиргааны байгууллага, зохицуулах байгууллага, үйлчлэгчдэд хандан дараах зөвлөмжийг гаргаж, хэрэгжүүлэхийг уриалж байна:

#### Нэг. Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЦХХХЯ):

- Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс гаргаж байгаа санал санаачлагыг хүлээн авч төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;
- “Улс хоорондын шуудангийн холбоо” ТББ-тай хамтарсан уулзалт зохион байгуулж, санал солилцсоны дагуу шуудангийн үйлчигээ эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлах, хамтран ажиллах;
- Цахим худалдаа, логистикийн чиглэлийн хууль, эрх зүй, зохицуулалтын орчинг сайжруулах;
- Хаягийн стандарт, шуудангийн нэгдсэн кодыг бусад төрийн байгууллагуудтай хамтран нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулах;
- Шуудангийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тал дээр анхаарал хандуулах;

#### Хоёр. Зохицуулах байгууллага (ХХЗХ):

- Шуудангийн тухай хууль болон дүрэм, журам, стандартуудыг мөрдүүлж хэвшүүлэх, хэрэгжилтийг үнэлж, дүгнэх аргачлал, зөвлөмжөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг дэмжин ажиллах;
- Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс гаргаж байгаа санал санаачлагыг хүлээн авч төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;
- Шуудангийн салбарын зохицуулалтын бодлогод дараах саналуудыг тусгах  
Үүнд:
  - Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хооронд өрсөлдөөний бус нэгдэн нийлэлт, харилцан холболтын зарчмаар ажиллах;

- Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийг үнийн өрсөлдөөн бус үйлчилгээний өрсөлдөөн бий болгох нөхцөлийг бүрдүүлэх;
- Технологи суурьтай шуудангийн үйлчилгээ эрхэлж байгаа үйлчилгээ үзүүлэгчдийн давуу талыг дэмжих;
- Шуудангийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох, шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээний тусгай зөвшөөрөл олголтод анхаарах;
- Шуудангийн илгээмж хүргэх хяналтын хугацааг тогтоож, шаардлагатай бол өөрчлөлт оруулах;
- Шуудангийн авто тээврийг хэрэгслийг авто зогсоол дээр саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлэх, дугаарын хязгаарлалт, нэгдүгээр эгнээр зорчих асуудлыг шийдвэрлэх;

Гурав. Төрийн захиргааны байгууллага: (ГЕГ, УХШИГГ)

- Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам” - ын шинэчилсэн төсөлд шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Гаалийн байгууллага шуудангаар үйлчлүүлэгчид нээлттэй болох;
- Цахим гаалийн системийг сайжруулах, гаалийн мэдүүлгийг цахимаар өгөх боломжийг бүрдүүлэх;
- Гаалийн мэдүүлэг авдаг олон төрлийн маягтуудыг цэгцлэх;
- Шуудангийн тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс хяналт шалгалтын цагийн хуваарьт уян хатан хандах.

Дөрөв. Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд:

- Шуудангийн салбарт мөрдөгдөх хууль эрх зүй хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Үйлчлүүлэгчид шуудангийн стандарт, шуудангийн үйлчилгээний технологи ажиллагааны дагуу ажиллах (MNS 6775:2019, MNS 5539:2019, MNS 6776:2019);
- Шуудангийн үйлчилгээний чанар, хүргэлтийн хугацаа мөрдөлт, найдвартай байдлыг ханган ажиллах;

- Шуудангийн хаягийн бичвэр, шуудангийн нэгдсэн кодыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн, үйлчлүүлэгчдэд хаягийн бичвэрийн заавар зөвлөгөө өдөр тутам өгч байх;
- Шуудангийн салбарт ажиллагсадыг мэргэшүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлыг зохион байгуулах;
- Шуудангийн байгууллагууд цар тахал, гамшгийн үед ажиллах шуудан хүргэх нөөц төлөвлөгөөтэй байх;
- Аймаг, орон нутгийн удирдлагын байгууллагуудаас дэмжлэг авч, эрсдэлийн сан байгуулах ажлыг зохион байгуулах;
- Технологийн дэвшилд суурилсан шинэ нэр төрлийн шуудангийн үйлчилгээг нэвтрүүлэх Үүнд:
  - Шуудангийн ухаалаг хайрцгийн үйлчилгээ
  - Хүргэлтийн хугацаанаас хамааран үнэ тариф ялгаатай тогтоох.  
Жишээ нь: 24 цагийн доторх хүргэлтийн үйлчилгээний тариф 24-48 цагийн энгийн хүргэлтийн үйлчилгээний тарифаас үнэтэй байх гэх мэт
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг дээдлэн шуудангийн илгээмжид агуулагдах зүйлсийг Монгол Улсын болон олон улсын хууль тогтоомжид нийцүүлэн үйлчлүүлэгчээс хүлээн авч дамжуулах.